



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 12 сарын 02 өдөр

Дугаар А/51

Улаанбаатар хот

Уралдааны удирдамж батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.9, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр нийслэлийн хэмжээнд 2022 онд авч хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Нийслэлийн хөгжлийн эрх зүйн орчин, бодлого төлөвлөлт, төсөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үзэл баримтлал, арга зүйг нэвтрүүлэх, бүх шатны төрийн албан хаагчдын мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор зохион байгуулах уралдааны удирдамжийг хавсралтаар баталсугай.

2. "Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөвлөлт"-ийн сорил, уралдаанд идэвхитэй оролцохыг газрын нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэн тайлагнахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150590258